

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ  
2020 ОНЫ 07 ДУГААР САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2020 оны 07 дугаар сарын 31-ний өдөр

Багануур дүүрэг

№	ҮНДЭСЛЭЛ	ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ
1.	2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.1	“Мон – Энержи Консалт” ХХК-ийн гүйцэтгэж байгаа паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийн нэгдсэн дүгнэлт гарсан.	100%
2.	БҮТП-ийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл	Техникийн нөхцөлийг олгох асуудал шийдэгдээгүй байна.	100%
3.	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамж	Нутаг консалтинг ХХК-ийн гүйцэтгэсэн Паркийн Үйлдвэрийн албан конторын барилгын Зураг төслийн нэгдсэн дүгнэлт гарч, 2020 оны 07 дугаар сарын 20-ны өдөр актаар хүлээн авсан.	100%
4.	БҮТП-ийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө	Байгууллагын хөгжлийн II дунд хугацааны 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарсан тул батлуулах хугацааг хойшлуулав.	90%
5.	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажилласан ба “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хариутай 5, хариугүй 6 бичиг нийт 11 албан бичиг ирсэн ба хариутай бичгийн шийдвэрлэлт, хариугүй бичгийн хаалт тус бүр 100 хувьтай байна. “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-аас ААНБ-уудад нийт 12 хариугүй бичиг явуулсан ба шийдвэрлэлт 100 хувьтай байна.	100%
6.	2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.2.1	Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт болон Нийслэлийн Засаг даргын А/108, А/168 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах үүднээс үндсэн үйл ажиллагааны болон цаг үеийн холбогдох мэдээллийг байгууллагын baganuur-itp.mn цахим хуудсанд тасралтгүй байршуулан ажиллаж байна.	100%
7.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	Мэдээллийн агуулга, стандартын дагуу шилэн дансыг хөтлөн байгууллагын цахим хуудсанд байршуулсан ба нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу бусад үүрэгт ажлыг хугацаанд нь гүйцэтгэж ажилласан. 2020 оны 02 дугаар улирлын тайлан, баланс гаргасан.	100%
<b>НЭМЭЛТ АЖИЛ</b>			



8.	Нийслэлийн Засаг даргын А/108 дугаар захирамжийн биелэлтийг 7 хоног бүрийн пүрэв гарагт zendmaal@gmail.com цахим хаягаар хүргүүлэн ажиллаж байна.	100%
9.	Нийслэлийн Засаг даргын А/168 дугаар захирамжийн биелэлтийг 14 хоног бүр гарган НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.	100%
10.	Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн танилцуулга болон төлөвлөгөөг бэлтгэж УУХҮЯ-нд хүргүүлэв.	100%
11.	Үндэсний их баяр наадмыг угтан зохион байгуулагдсан бүх нийтийн их цэвэрлэгээнд оролцож тайланг Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 133 дугаартай албан бичгээр дүүргийн ЗАА-нд хүргүүлсэн.	100%
12.	Байгууллагын 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төсөөллийг бэлтгэж Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2020 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 136 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.	100%
13.	2020 оны 07 дугаар сарын 21-ний өдөр Тарваган тахал өвчин зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зөвлөмжийг албан хаагчдад танилцуулсан.	100%
14.	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 219 дугаар танхимд 2020 оны 07 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулагдсан Тоон гарын үсэг хэрэглэх тухай сургалтанд Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн М.Мөнхдулам оролцов.	100%

ХЯНАСАН:

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК  
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН.  
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

*Signature*

Б. НОМИНЗУЛ